



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 8/134

Хэрлэн сум

Н.Баярсайханыг ажилд
түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 43 дугаар зүйлийн 43.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн даргаар Нармандахын Баярсайханыг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс ажилд түр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын

дарга: Ч.Баярцолмон

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Э.Ариунтунгалаг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч

Т.Баяртуяа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нярав

3. Н.Баярсайханы сарын үндсэн цалинг TY-10 зэрэглэлээр тогтоон, 1,286,000 (нэг сая хоёр зуун наян зургаан мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Н.Баярсайханд үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ГАНТУЛГА